



**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД,
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

ЗАГВАР ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

/Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн мэргэжлийн үнэмлэх/

2014 оны 02 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 25/А/30

Улаанбаатар хот

Автотээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т заасныг үндэслэн Тушаах нь:

1. “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн мэргэжлийн үнэмлэх”-ний загварыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Батбаатар/, Боловсрол, шинжлэх ухааны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Эрдэнэчимэг/-т тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Сургалтын хөтөлбөр, журам, үнэмлэхний загвар батлах тухай” Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 161/229 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

А.ГАНСҮХ

Л.ГАНТӨМӨР

Зам, тээврийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2014 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 25/А/30 хамтарсан тушаалын хавсралт

Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн мэргэжлийн үнэмлэхний загвар

Тээврийн хэрэгслийн ангилал / Categories of vehicle /			Дуусах хугацаа / Date of expire
B		᠙ <750 kg < 8 ᠎	... он ... сар ... өдөр
C		᠙ <5000 kg	... он ... сар ... өдөр
CE		᠙ >5000 kg	... он ... сар ... өдөр
D		᠙ <750 kg ; > 8 ᠎	... он ... сар ... өдөр
МЭРГЭШИЛ ДЭЭШЛҮҮЛЭЛТ			Дуусах хугацаа / Date of expire
Аюултай ачаа болон овор ихтэй, урт, хүнд ачаа тээвэр			... он ... сар ... өдөр
Улс хоорондын ачаа тээвэр			... он ... сар ... өдөр
Улс хоорондын зорчигч тээвэр			... он ... сар ... өдөр
Жуулчин тээвэр			... он ... сар ... өдөр



Олгосон байгууллагын нэр / Тамга /

Олгосон огноо / Date of issue

... он ... сар ... өдөр



№ 0000001



МОНГОЛ УЛСЫН МЭРГЭШСЭН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ
MONGOLIAN PROFESSIONAL DRIVER'S LICENSE

<p>Ургийн Овог / Family name БОРЖИГОН BORJIGON</p> <p>Эцэг/эх/-ийн нэр / Surname БОЛД BOLD</p> <p>Өөрийн нэр / Given name БААТАР BAATAR</p> <p>Регистр № / Registration № ЧД 80010101</p> <p>Гарын үсэг / Signature</p>	<p>Үнэмлэхний дугаар / Card number № 0000001</p> <p>Ангилал / Category B C D E</p> <p>Төрсөн он / Date of birth 1980-01-01</p> <p>Иргэншил / Nationality Монгол / Mongolia</p> <p>Хүйс / Sex Эр / M</p> <p>Нүдний өнгө / Eyes Хар / Black</p>
---	--

Тайлбар:

- үнэмлэхний дэвсгэр өнгө нь цагаан цэнхэр, торон хээн суурьтай, зүүн хэсэгт бөмбөлөг хэлбэрийн мушгиа хээний хагас байх бөгөөд нүүрэн талын дээд хэсэгт “Монгол улсын мэргэшсэн жолоочийн үнэмлэх” гэж Монгол, Англи хэлээр бичнэ;
- “Монгол улсын мэргэшсэн жолоочийн үнэмлэх” -ний зүүн дээд өнцөгт Монгол Улсын “Төрийн далбаа”, нүүрэн талын голд “Төрийн соёмбо” шар өнгөөр, ар талд баруун дээд өнцөгт “MGL” гэсэн ялгах тэмдэг, баруун доод өнцөгт хүн тус бүрийн QR код байрлуулсан байна;
- нүүрэн талд хэт ягаан туяаны тусгалд тодрох “Автотээврийн билэг тэмдэг” -ийг өнгөтөөр, олон улсын шаардлагад нийцсэн голограммын нууцлалтай байна;
- жолоочийн зураг 3x4 харьцаатай;
- бичвэрийг Arial үсгийн фонтыг ашиглан бичнэ. Бичвэрийн үсгийн хэмжээ нь 6-8 байна.